МЭДЭЭ · 2021 оны 5-р сарын 14

ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТАРСАН ЗӨВЛӨГӨӨН ХИЙЖЭЭ



Дундговь аймгийн прокурорын газраас санаачлан ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын ажлын чиглэлээр тус аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар болон Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтарсан зөвлөгөөн хийсэн байна.

Зөвлөгөөнөөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах талаар харилцан мэдээлэл солилцож, хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудад мэргэжлийн сэтгэл зүйчээр сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдад сургалт зохион байгуулах зэрэг шат дараатай ажил, арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2894